



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/15

Мандалговь

Малчин өрхөд малын тэжээл олгох ажлыг зохион байгуулах ажлын хэсэг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 213 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 03 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл"-ийн хүрээнд сумдын малчин өрхүүдэд малын тэжээл хүргүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай. Үүнд:

Дарга:	М.Анхбаяр	(Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд:	Б.Мөнхжаргал	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
	М.Адъяабаатар	(Онцгой байдлыг газрын дарга)
	С.Энхжаргал	(Төсвийн ерөнхий санхүүч)
Нарийн бичгийн дарга:	Ж.Батбилэг	(Хүнс хөдөө аж ахуй газрын Мал үржлийн албаны дарга)

Хоёр. Аймгийн болон Улсын нөөцийн салбарын агуулахын бэлэн байдлыг хангах, тээвэрлэгдэн ирсэн тэжээлийг бүртгэх, ачиж буулгах, хуваарилах ажлыг журмын дагуу төлөвлөн хэрэгжүүлэхийг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210031